



ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН БҮРТГЭЛИЙН ХУРААМЖИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2023.06.30

Улаанбаатар хот

Хуульчийн мэргэжлийн шалгалтыг “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль” болон Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн мэргэжлийн шалгалтын журам”¹-д заасан журмын дагуу зохион байгуулж байна. Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын §4.2.5-д “Шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг энэ журмын 3.6 дугаар зүйлд заасан төсвийн зардалтай уялдуулан Хуульчдын холбооны Зөвлөл тогтооно” гэж зохицуулсныг үндэслэн Зөвлөлөөс хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг тогтоох зохицуулалттай.

Өнөөдрийн байдлаар МХХ-ны Зөвлөлийн 2021 оны 06 сарын 05-ны өдрийн №12 дугаар тогтоолын дагуу хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг **80,000 /наян мянган/** төгрөгөөр тогтоож байсан байна. Энэхүү бүртгэлийн хураамжийн хэмжээгээр 2021 оноос хойш зохион байгуулсан 2 удаагийн шалгалтын зардал хүрэлцэхгүй байсны улмаас зарим зардалыг МХХ-ны гишүүн хуульчдын татвараар нөхөж санхүүжүүлж ирсэн байна.

Иймд тус хураамжийн хэмжээг бодитоор харж судлах, бодит мэдээлэл, гарах зардлын хэмжээг үндэслэн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг өөрчлөх саналыг Монголын Хуульчдын холбооны Зөвлөлд танилцуулж байна.

Нэг. Судалгаа

Шалгалтын хорооны зүгээс нэн тэргүүнд холбогдох хууль, шалгалтын журамд заасан зохицуулалтыг судалж авч үзлээ.

Нэгдүгээрт, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлд Хуульчдын холбооны чиг үүрэгт хамаарах 10 үүргийг² оноон тодорхойлсон

¹ Тус журам нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 3745 дугаарт бүртгэгдсэн. Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн хурлын 2018 оны 23 дугаар тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлт орсон.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=207879&showType=1>

² Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

45 дугаар зүйл. Хуульчдын холбооны чиг үүрэг

45.1. Хуульчдын холбоо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

45.1.1. хуульчийн шалгалт зохион байгуулах;

45.1.2. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

45.1.3. хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох;

45.1.4. хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

45.1.5. Хуульчийн мэргэжлийн дүрэм батлах, сахиулах;

45.1.6. Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулан ажиллуулах;

45.1.7. шүүгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулахад өрөлцөж;

/Тус заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

45.1.8. хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх;

45.1.9. хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх;

бөгөөд §45.1.1-д “хуульчийн шалгалт зохион байгуулах” гэж тодорхойлсон. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §7.1-д “Хуульчийн мэргэжлийн шалгалт /цаашид “хуульчийн шалгалт” гэх/-ын зорилго нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахыг хүссэн этгээдийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаанд оролцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх хангалттай мэдлэг, чадвар эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэнэ” гэж заасан. Мөн хуулийн §62.3-т “Хуульчдын холбооны санхүүжилт нь гишүүдийн татвар, хандив, хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж, сургалтын төлбөр, хэвлэн нийтлэлийн ашгаас бүрдэнэ” гэж заасан байна. Иймээс хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчдын мэдлэг, чадвар эзэмшсэн эсэхийг тогтоох шалгалтын санхүүжилт нь хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж байхыг тодорхой зааж хуульд зохицуулжээ гэж үзлээ.

Хоёрдугаарт, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §16.6-д “Хуульчийн шалгалттай холбогдох бусад асуудлыг Хуульчдын холбооноос баталсан журмаар зохицуулна” гэж заасан байна. Тус журмын хувьд буюу Зөвлөлөөс баталсан дурдсан Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмаар Шалгалтын комиссыг бүрдүүлэх гишүүдийн тоо, төлөөлөл, тэдгээрт олгох урамшуулал, шалгалтын зардлын төсөв, тус төсвөөр хийж гүйцэтгэх ажлыг нарийвчлан зохицуулсан байна. Тус журмын §3.7.1-д “Шалгалтыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлын төсвийг Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны өргөн мэдүүлснээр Хуульчдын холбооны зөвлөл батална”, 4.2.4-д “Шалгалтад бүртгүүлэхтэй холбогдон гарах зардлыг оролцогч өөрөө хариуцна”, 4.2.5-д “Шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг энэ журмын 3.6 дугаар зүйлд заасан³ төсвийн зардалтай уялдуулан Хуульчдын холбооны Зөвлөл тогтооно” гэж тодорхойлсон байна.

Эдгээр дурдсан зохицуулалтуудаас харвал хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээ нь Шалгалтын комиссын гишүүд, шалгалтыг зохион байгуулахад оролцох бүрэлдэхүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээ, Шалгалтын комиссын хийж гүйцэтгэх ажлын зардлын хэмжээ болон зохион байгуулах ажлын зардлын хэмжээтэй шууд уялдаатай нь харагдаж байна.

Шалгалтын нийт төсвийн хувьд Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын “Хуульчийн мэргэжлийн шалгалтын журам”-ын 3.7.1-д “Шалгалтыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлын төсвийг Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны өргөн мэдүүлснээр

45.1.10.хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх;

45.1.11.мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа зохион байгуулах;

45.1.12.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх.

/Тус заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

³ 3.6 дугаар зүйл.Шалгалтын комиссын гишүүнд урамшуулал олгох

1.Шалгалтын комиссын гишүүнд урамшуулал олгох асуудлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7, 52.8 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

Хуульчдын холбооны зөвлөл батална” гэж зохицуулсан байх бөгөөд жил бүрийн шалгалтын төсвийг Зөвлөлөөс баталж ирсэн.

Судалгаа мэдээлэл бэлтгэх үеийн байдлаар Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын зүгээс үнийн санал авч бэлтгэн гаргасан 2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах ажлын төсөв /урьдчилсан төсөөлөл, үнийн санал/-ийн хувьд **256,297,950** орчим төгрөгийн зардал гаргахыг урьдчилан бэлтгэж гаргасан байна.

Хүснэгт №1: 2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах зардлын ерөнхий төсвийн төсөөлөл

№	Зардлын ангилал	Төсөөлсөн төсөв /төгрөгөөр/
1	Бичиг хэргийн нийт зардал	15,000,000
2	Түрээсийн зардал	120,000,000
3	Өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, төлбөртэй и-мэйл явуулах мэдээллийн зардал	400,000
4	Шалгалтын комиссын гишүүд, шалгалтыг зохион байгуулахад оролцох бүрэлдэхүүний хоол, цайны зардал /шалгалтын 5 хоног, нийт 90* хүн/	21,355,000
5	Шалгалт зохион байгуулах болон дүгнэх комиссын гишүүд, шалгалтыг зохион байгуулахад оролцох бүрэлдэхүүний ажлын хөлс буюу урамшуулал /НДШ багтсан дүнгээр/	78,335,950
6	Программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр авах ажлын хөлс /НДШ багтсан дүн/	18,000,000
7	Бусад зардал <ul style="list-style-type: none"> ● Шатахууны зардал ● Анонс ● Хэвлэлтийн зардал ● Танхимын түрээс /ХЗҮХ/-ийн зардал ● Принтерийн түрээсийн зардал 	8,900,000
8	<u>НИЙТ ДҮН</u>	<u>256,297,950</u>

* Шалгалтыг улсын хэмжээнд Зөвлөлөөс тогтоосон товын дагуу жилдээ нэг удаа нэгэн зэрэг нийт 9 шалгалтын салбар хороогоор зохион байгуулдаг бөгөөд нэг салбар хороонд Шалгалтын комиссийн бүрэлдэхүүнээс 2 гишүүн, салбарын нарийн бичиг 1, ТГ-ын ажилтан 2, улсын бүртгэлийн ажилтан 1, цагдаагийн ажилтан 2, хөндлөнгийн хяналтын ажилтан 2 хүн нийт нэг салбарт 10-аад хүний бүрэлдүүнтэй ажилдаг /шалгалтад оролцогчдын тооноос хамаарч салбарын тоо нэмэгдэж хасагддаг/.

Зардлуудын хувьд, бичиг хэргийн нийт зардлын хувьд бичгийн цаас, скоч, бал, тэмдэглэлийн хуудас г.м нийтлэг, түгээмэл ашиглагддаг бараа, материалын зардал гардаг.

Түрээсийн зардлын хувьд дээрх төсвийг бэлтгэхэд жил бүр тус шалгалтыг хамтран зохион байгуулж байсан цахим тоглоомын төвүүдээс түрээсийн үнийн саналыг авч бэлтгэсэн. Цахим тоглоомын төвүүд нь өдөр суудлаа түрээслэхээс гадна шөнийн цагаар мөн суудлаа түрээслэн ашигладаг. Хуульчийн шалгалтын хувьд 3 хоногийн хугацаанд авдаг бөгөөд энэ хугацаанд цахим тоглоомын төвийн шөнийн түрээсийн зардлыг давхар төлөхөөс өөр боломж байхгүй байна. Түрээсийн үнийн хувьд өсөлт их байгааг тусгайлан дурдаж байна. Нийт оролцогчдын тооноос хамааран цахим тоглоомын төвийн танхимын түрээсийн зардал хэлбэлзэх, нэмэгдэх бөгөөд Шалгалтыг зохион байгуулах болон дүгнэх комиссын гишүүд, шалгалтыг зохион байгуулахад оролцох бүрэлдэхүүнд олгох урамшууллаас бусад зардлууд дагаж өсөхөөр ажиглагдаж байна.

Шалгалт зохион байгуулах болон дүгнэх комиссын гишүүд, шалгалтыг зохион байгуулахад оролцох бүрэлдэхүүний хоол, цайны зардал болон тэдгээрт олгох ажлын хөлс, урамшууллын зардлын хувьд **авч үзвэл:**

Шалгалтын комиссын гишүүдэд олгох урамшууллын хувьд, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §8.1-д *“Энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос байгуулагдсан Хуульчийн шалгалтын комисс /цаашид “Шалгалтын комисс” гэх/ хуульчийн шалгалтыг зохион байгуулна*”, §52.4-д *“Шалгалтын хороо хуульчийн шалгалт зохион байгуулах тухай бүрд Шалгалтын комиссыг байгуулна*”, §52.5-д *“Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд энэ хуулийн 8.2-т зааснаас гадна Тамгын газрын шалгалт хариуцсан ажилтан болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгч заавал орно*”, §8.2-д *“Шалгалтын комисст шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны болон хуульч профессоруудын төлөөлөл орно”* гэж зохицуулсан. Тус зохицуулалтын дагуу жил бүр хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулахаас өмнө шалгалтын комиссыг байгуулж ажилладаг. Шалгалтын комисс нь хуульд заасны дагуу⁴ хуульчийн шалгалтыг зохион байгуулах; сорилгын болон бодлогын шалгалтад оролцогчдын даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх; хуульчийн шалгалтын дүнг үнэн зөв нэгтгэн Шалгалтын хороонд хүргүүлэх; шалгалтын даалгаврын боловсруулалт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах зэрэг үүргийг гүйцэтгэж ажилладаг. Эдгээр орон тооны бус комиссын гишүүдэд жил бүр зардал гаргаж ирсэн. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §52.7-д *“Тамгын газрын шалгалт хариуцсан ажилтан болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчөөс бусад шалгалтын комиссын гишүүнд урамшуулал олгоно”*,

⁴ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

52.6.Шалгалтын комисс нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

52.6.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хуульчийн шалгалтыг зохион байгуулах;

52.6.2.сорилгын болон бодлогын шалгалтад оролцогчдын даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх;

52.6.3.хуульчийн шалгалтын дүнг үнэн зөв нэгтгэн Шалгалтын хороонд хүргүүлэх;

52.6.4.шалгалтын даалгаврын боловсруулалт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

§52.8-д “Энэ хуулийн 52.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, энэ хуулийн 52.7-д заасан урамшууллыг олгох журмыг Зөвлөл тогтооно”, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын §3.6.1-д “Шалгалтын комиссын гишүүнд урамшуулал олгох асуудлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7, 52.8 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан тул шалгалтын комисст орсон шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны болон хуульч профессоруудын төлөөлөлд хуульд тодорхойлсон чиг үүргийг гүйцэтгүүлсний төлөө урамшууллыг олгож ирсэн.

Шалгалтын комиссын гишүүдийн тооны хувьд Шалгалт зохион байгуулах журамд заасны дагуу Шалгалтын хороо нь шалгалтын зорилго, төрөл, зохион байгуулагдах үйл ажиллагааг харгалзан Шалгалтын зохион байгуулалтын комисс; болон Бодлогын шалгалтын даалгаврыг дүгнэх комиссыг тус тус байгуулж ажилладаг. Шалгалтын зохион байгуулалтын комисс нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д заасан төлөөллийг хангасан 13-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байдаг бол Дүгнэх комисс нь мэргэжлийн ёс зүйн алдаа зөрчилгүй, хууль зүйн магистр ба түүнээс дээш зэрэгтэй Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хороо болон хуульч профессорын тэнцвэртэй тооны төлөөллийг хангасан 15-27 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагддаг. Эдгээр бүрэлдэхүүний гишүүнд олгох урамшууллын хэмжээг МХХ-ны Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор дараах хэмжээгээр тогтоосон. Тус урамшууллын хэмжээг 2023 онд хэвээр мөрдөж ажиллана.

Хүснэгт №2: Шалгалтын комиссын гишүүдэд олгох урамшууллын хэмжээ

№	Урамшууллын төрөл	Урамшууллын хэмжээ /төгрөгөөр/	Тогтоол
1.	Хуульчийн мэргэжлийн шалгалтын зохион байгуулалтын комиссын гишүүнд олгох урамшуулал	650, 000	МХХ-ны Зөвлөлийн 2021.06.05-ны №13 тогтоол
2.	Бодлогын даалгавар дүгнэх комиссын гишүүнд олгох урамшуулал	780,000	

Эдгээр мэдээллүүдийг нэгтгэж Шалгалтын зохион байгуулалтын комиссын 16 гишүүн, Дүгнэн шалгах комиссын 27 гишүүн, Дахин дүгнэх комиссын 27 гишүүний урамшууллыг зөвхөн дээр баталсан хэмжээгээр тооцож үзэхэд **47,238,750** орчим төгрөгийн урамшууллын зардалд гэхэд гарч байгааг харж байна. Шалгалт зохион байгуулах, дүгнэхэд оролцсон нийт гишүүдийн хоол, цайны зардлыг гишүүдийн тооноос хамаарсан зардал бөгөөд зах зээлийн дундаж үнээр тооцож гаргасан.

Программ хангамж, мэдээллийн технологийн ажлын хөлсний хувьд сорилгын болон бодлогын шалгалтын систем хариуцах ажилтны ажлын хөлсийг оруулж тооцсон бөгөөд бусад зардлын хувьд зохион байгуулалтын ажлыг

шуурхай, ил тод, тодорхой зохион байгуулахад шаардлагатай Шалгалтын комиссын ажиллах зохион байгуулалтын зардлуудыг багтаасан.

Төсвийг бэлтгэхэд үнийн өсөлт их байгаа нь ажиглагдсан. Монголын Хуульчдын холбоо байгуулагдсанаас хойших өнгөрсөн 10 жилийн хугацаанд дундаж цалин хөлс 3 дахин нэмэгдэж, бараа бүтээгдэхүүний үнэ 3-4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн үнийн энэхүү өсөлт, нөхцөл байдлаас шалтгаалан бичиг хэрэгсэл, түрээс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хоол зууш зэрэг шалгалтын зохион байгуулалтад шаардагдах үндсэн зардлыг бүрдүүлж буй бараа материалын үнэ тухайн үеийнхээс 3 дахин нэмэгдсэн байна.


Монголын Хуульчдын холбоог үүсгэн байгуулсан 2013 онд Монголбанкны ханшаар төгрөгийн америк доллартой харьцах ханш 1,289 төгрөг байсан бол 2023 оны 06 сарын 13-ны өдрийн хаалтын ханшаар төгрөг долларын харьцах ханш 3,440.35⁵ төгрөг болж төгрөгийн доллартай харьцах ханш 2,6 дахин буурсан байна.

Зураг №1: Монголбанкны мэдээллийн сан дах валютын ханшийн мэдээлэл



Инфляц, валютын ханш, үнийн энэ өсөлтөөс үүдэн 2019 оноос хойших мэдээллийг авч үзвэл Монголын Хуульчдын холбоо сүүлийн 4 удаа бодит гүйцэтгэлээр гарсан хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулахад гарсан илүү зардлыг хуульчийн гишүүний татварын мөнгөнөөс санхүүжүүлж ирсэн байгааг тусгайлан дурдаж байна.

Зураг №2. Хуульчийн мэргэжлийн шалгалтын төсөв, бодит зардлын зөрүү алдагдал




⁵ <https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

Дээр дурдсан зохицуулалтаас харвал шалгалтад бүртгүүлэгч нь зардлаа өөрөө хариуцахаар нэгэнт зохицуулсан байх тул зардлын зөрүү үүсэх нөхцөлд хуульчдын татварын мөнгөнөөс зөрүүг нөхөхөөс сэргийлж бодит гарах зардалтай уялдуулж хураамжийг тогтоохыг Шалгалтын хорооны зүгээс түлхүү баримталлаа.

Шалгалтад бүртгүүлэгчдийн тоон мэдээллийн хувьд сүүлийн 4 жилийн мэдээллийг авч үзвэл дараах байдалтай байна.

Зураг №3: Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцохоор бүртгүүлэгчдийн тоо /сүүлийн 4 жилийн байдлаар/



Тус мэдээлэл дээр үндэслэн шалгалтад оролцогчдын тоог дунджаар 1,300 орчим байна гэж үзсэн. Гэхдээ тусгайлан анхаарах асуудлын хувьд Улсын Дээд шүүхээс “хуульчийн мэргэжлийн боловсролыг эзэмшиж, хуульчаар бэлтгэгдэж байгаа оюутан төгсөхдөө 120 багц цагийг хангасан байх ба оюутны суралцах хугацаа дөрвөн жилээс багагүй байна” гэх заалт нь Монголын Хуульчдын холбоо хуулийн сургуулийг магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хуульчийн мэргэжлийн шалгалтад ороход баримтлах суурь шаардлага бөгөөд хуулийн сургуулийг магадлан итгэмжлээгүй атлаа эчнээ, орой ангийн хөтөлбөрөөр суралцаж эрх зүйч мэргэжил эзэмшсэн этгээдийг бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” зарчимд нийцэхгүй гэсэн үндэслэлээр⁶ хуулийн сургуулийн “**их дээдийн**” болон “**эчнээ**” анги төгсөгчдийг хуульчийн сонгон шалгаруулалтад бүртгээгүй нь хууль бус гэж үзсэн шийдвэр гараад байгааг дурдаж байна. Тус асуудлыг Шалгалтын хороо цаашид судлан шийдвэрлэх бөгөөд уг шийдвэртэй холбогдуулан шалгалтад бүртгүүлэгчдийн тоо өсөх боломж байгааг мөн анхаарах шаардлагатай байгааг уламжилж байна.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамжтай холбоотой тоон мэдээллээс харвал **2019 онд 6,716,085 төгрөг, 2020 онд 7,055,918 төгрөг, 2021 онд 25,665,786 төгрөг, 2022 онд 47,164,505 төгрөгийн** зардлыг хураамжийн зардал дээрээс нэмж Монголын Хуульчдын холбооны гишүүдийн татвараас санхүүжүүлсэн байна. Ялангуяа 2021 оноос хойш хуульчийн

⁶ Эх сурвалж: <https://www.supremecourt.mn/home?page=pages&id=118&pg=2978&pr=115&tp=list&h=0>

мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг нэмэгдүүлсэн байх боловч дагаад бодитоор гүйцэтгэсэн гүйцэтгэлийн зардал огцом нэмэгдсэн байгаа бөгөөд энэ жил хураамжийн хэмжээг бодитой нэмэхгүй бол цаашид хуульчдын татвараас санхүүжүүлэх явдал давтагдах боломжтой байгааг анхааралдаа авна уу.

Хүснэгт №3: Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамжтай холбоотой тоон мэдээлэл /сүүлийн 4 жилийн байдлаар/

№	Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулсан он	Хуульчийн мэргэжлийн шалгалтад бүргүүлсэн хүний тоо	Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамжийн хэмжээ /төгрөгөөр/	Төлөвлөсөн төсөв /төгрөгөөр/	Бодит гүйцэтгэл /төгрөгөөр/	Зөрүү /төгрөгөөр/
1	2019	1,243	50,000	62,150,000	68,866,085	6,716,085
2	2020	1,340	50,000	67,000,000	74,055,918	7,055,918
3	2021	1,291	80,000	103,280,000	128,945,786	25,665,786
4	2022	1,228	80,000	98,240,000	145,404,505	47,164,505

Үнийн өсөлтийн хувьд товч авч үзэхэд Монгол Улсад ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлтөөр авч үзвэл 2020 оны 12 сараас 2021 оны 12 сар хүртэл инфляц 3% өсөж 16.2% болсон буюу 13% орчим хувиар өссөн өндөр үзүүлэлттэй гарсан байна.



Зураг №4: Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт /хувиар/.

Эх сурвалж: YCX, Монголбанк

Инфляцтай уялдсан хэрэглээний үнийн индексийг авч үзвэл сүүлийн 3 жил тасралтгүй өссөн байна.

Зураг №5: Хэрэглээний үнийн индексийн мэдээлэл. Эх сурвалж: YCX www.1212.mn

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 I-V	2022 I-V	2023 I-V
Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан)	хувь	0.9 ^{0.8}	1.3 ^{44.4}	1.3 ^{0.0}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны эцэстэй харьцуулсан)	хувь	5.7 ^{3.8}	8.0 ^{40.4}	6.3 ^{-21.3}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан)	хувь	6.1 ^{2.9}	16.2 ^{27.7}	11.3 ^{-30.2}

Цаашлаад Монголбанкны зүгээс 2023 он, 2024 оны инфляцын төсөөллийг 2023 онд 7.2%, 2024 онд 6.5% гэж төсөөлсөн боловч 2023 оны эхний улирлын байдлаар бодит инфляцын гүйцэтгэл улсын хэмжээнд 12.2%, Улаанбаатар хотод 12.1% байна.

Зураг №6. Инфляцын төсөөлөл /хувиар/.

Инфляцын төсөөлөл				
	2021	2022*	2023*	2024*
		төсөөлөл		
Инфляц ⁴	11.4	14.7 [13.2-16.2] ⁵	7.2 [5.4-8.9]	6.5 [5.2-7.8]

Эх сурвалж: Монголбанк

Гэтэл бодит байдал дээр инфляцын төсөөлөл алдагдаж бодит байдал дээр махнаас бусад дотоодын хүнсний үнэ 2023 оны 2 дугаар сард жилийн 28.4 хувиар өссөн үзүүлэлт гараад байна⁷. Эдгээр хүчин зүйл нь шалгалт зохион байгуулах зардлыг сүүлийн 2-3 жил тогтвортой өсгөсөн байна гэж үзлээ. Энэхүү үнийн өсөлтөөс улбаалан энэ жил шалгалт зохион байгуулах ажлыг төсөвлөхөд зардал мөн нэмэгдэж байх тул хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх бодитой хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Монголын Хуульчдын холбоо нь эрх зүйчдэд зориулан шалгалтаас өмнө төлбөртэй сургалт зохион байгуулдаг. Сургалтын онцлог нь эрх зүйн салбараар бодлого бодох, дүн шинжилгээ хийх аргачлалыг эзэмшүүлэхэд чиглэдэг бөгөөд их, дээд сургуулийн багш, сургалт зохион байгуулах арга зүй эзэмшсэн, сургалтын туршлагатай, нэр хүнд бүхий шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн төлөөллөөс хичээлийг удирдан явуулдаг. Сургалтын төлбөр нь сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зардал болох танхимын түрээсийн зардал, сургагч багшийн ажлын хөлс, сургалтын материалын бичиг хэрэг, хэвлэлтийн зардалд бүрэн зарцуулагддаг. Эрх зүйч, шалгалтад горилогч нар нар нь хуульчийн мэргэжлийн шалгалтад бэлтгэхтэй холбоотой бусад төрлийн сургалтад хамрагдах эрх нээлттэй, чөлөөтэй учир оролцогчдын тоог нарийн гаргах боломжгүй бөгөөд сургалтын төлбөрөөс хуульчийн мэргэжлийн шалгалтын санхүүжилтийн тодорхой хувийг санхүүжүүлэх бодит боломжгүй байдаг.

Шалгалт зохион байгуулах төсвөөс үлдэх нөхцөлд Монголын Хуульчдын холбооны арилжааны дансанд байршуулах, үлдээх бөгөөд бусад төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх, цаашид шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сайжруулахад чиглэсэн ажлыг хийх бодит боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хоёр. Санал

1. Үнийн өсөлт, өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан төсөвтэй уялдуулан бодитоор гарах зардлыг харгалзан шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг тогтоох.

2. Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын зүгээс гаргасан 2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах ажлын төсвийн төсөөллийг үндэслэн хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох эрх зүйчдийн тоог дунджаар 1,300 орчим байна гэж тооцож цаашид гишүүн хуульчдын татварын мөнгөнөөс нэмэлт санхүүжилт гаргахгүй байх, зардлын зөрүүг гишүүдийн татвараас нөхөхгүй байх зарчмыг баримталж 2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг **200,000 /хоёр зуун мянган/** төгрөгөөр тогтоох.

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО